

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2025/012/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Могойн гол ХК ба түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны мэдээлэл	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОГОЙН ГОЛ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТХҮҮ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/313
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Могойн гол ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол Могойн гол ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг хэмжээгээр нөлөөлж байгаа дараах асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулаагүй байна. Үүнд:

- Компанийн өр төлбөр эздийн өмчийн дүнгээс 2023 онд 1,853.0 сая төгрөг, 2024 онд 14,417.7 сая төгрөгөөр илүү болж төлбөрийн чадварыг алдагдуулж байна.
- Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 8,048.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ирээдүйн нүүрс борлуулалтын өртгийг материаллаг хэмжээгээр өсгөхөөр байна.
- Компанийн 2023 оны ногдол ашгийн өглөг 477.8 сая төгрөгийг өгөөгүй байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан татварын өмнөх ашгийн зорилтот түвшнээс 3,062.0 сая төгрөгөөр бага буюу 991.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 11,075.2 сая төгрөгөөр өсөж 17,813.3 сая төгрөг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар тасралтгүй байх чадавх, бизнес төлөвлөгөөний биелэлт, зардлын данс, худалдан авах ажиллагаатай холбоотой 3,606.1 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгсөн.

6725022132

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Могойн гол ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,500 төгрөг байсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	100,475,164.05	20,541,295.51
1.1.02	Дансны авлага	401,285,037.30	526,774,114.55
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	107,695,024.62	20,028,838.20
1.1.04	Бусад авлага	4,390,437.50	38,003,762.97
1.1.06	Бараа материал	8,216,479,429.72	16,573,378,784.98
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	625,185,313.61	668,727,329.61
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	11,709,156.12	446,592.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,467,219,562.92	17,847,900,718.41
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,966,201,857.60	3,167,651,623.53
1.2.02	Биет бус хөрөнгө	189,648,221.20	193,366,764.66
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,155,850,078.80	3,361,018,388.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,623,069,641.72	21,208,919,106.60
2.1.1.01	Дансны өглөг	2,151,932,391.17	8,971,335,061.23
2.1.1.02	Цалингийн өглөг	0.00	148,987,747.71
2.1.1.03	Татварын өр	618,539,846.32	599,393,850.84
2.1.1.04	НДШ - ийн өглөг	62,976,414.03	267,862,972.61
2.1.1.05	Богино хугацаат зээл	0.00	1,212,000,000.00
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	0.00	477,773,200.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	3,073,452,696.75	5,337,656,392.21
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	41,329,750.00	8,469,415.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,948,231,098.27	17,023,478,639.60
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	789,830,990.80	789,830,990.80
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	789,830,990.80	789,830,990.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,738,062,089.07	17,813,309,630.40
2.3.01	Өмч: - төрийн	42,310,722.00	42,310,722.00
2.3.02	- хувийн	40,651,478.00	40,651,478.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,375,789,181.23	1,375,789,181.23
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	202,833,326.81	202,833,326.81
2.3.09	Хуримтлагдсан ашиг	3,223,422,844.61	1,734,024,768.16
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-991,624,876.45
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	3,223,422,844.61	2,725,649,644.61
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,885,007,552.65	3,395,609,476.20
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,623,069,641.72	21,208,919,106.60

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,794,754,560.00	6,735,121,638.00
2	Борлуулалтын өртөг	5,808,585,091.00	6,013,803,917.00
3	Нийт ашиг(алдагдал)	2,986,169,469.00	721,317,721.40
8	Бусад орлого	56,240,141.82	48,824,326.78

8.1	Орлогын дүн	56,240,141.82	48,824,326.78
9	Борлуулалт, маркетингийн зардал	812,430,115.80	476,847,216.60
10	Ерөнхий ба удирдлагын зардал	906,438,804.30	1,154,038,607.00
12	Бусад зардал	527,724,892.60	130,881,101.50
12.1	Зардлын дүн	2,246,593,813.00	1,761,766,925.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	795,815,798.50	-991,624,876.50
19	Орлогын татварын зардал	130,658,082.20	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	665,157,716.30	-991,624,876.50
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	665,157,716.30	-991,624,876.50

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөг

Үзүүлэлт	Өмч	Хөргийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	3,598,878,332.29	5,260,463,040.33
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	0.00	0.00	0.00	-1,040,613,204.00	-1,040,613,204.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	665,157,716.32	665,157,716.32
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	3,223,422,844.61	4,885,007,552.65
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга	0.00	0.00	0.00	-497,773,200.00	-497,773,200.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-991,624,876.45	-991,624,876.45
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	1,734,024,768.16	3,395,609,476.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,566,369,559.34	9,225,481,040.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,456,216,704.05	9,137,221,879.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	110,152,855.29	88,259,161.00

1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,156,084,753.97	8,968,813,308.54
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,979,572,383.01	2,365,380,420.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	543,824,218.86	512,976,414.03
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,319,514,032.46	563,190,886.15
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	134,451,105.41	140,572,964.41
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,175,725,467.94	2,605,771,007.75
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	90,093,106.86
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	489,702,559.46	694,143,041.27
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	26,694,775.37	8,938,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,486,600,211.46	1,987,747,468.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,410,284,805.37	256,667,731.46
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	817,029,800.00	1,528,601,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	817,029,800.00	1,488,801,600.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	39,800,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-817,029,800.00	-1,528,601,600.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	1,212,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	1,212,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	948,745,775.30	20,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	948,745,775.30	20,000,000.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-948,745,775.30	1,192,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-355,490,769.93	-79,933,868.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	146,272,287.03	100,475,164.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	100,475,164.05	20,541,295.51

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн	Хувь
1	Урд оноос шилжсэн нүүрс	мян.тн	40.2	40.2	0.0	100.0
2	Хөрс хуулалт/мян.м3/	мян.м3	2,500.0	1,131.9	-1,368.1	45.3
3	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	140.0	-110.0	56.0
4	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	117.4	-132.6	47.0
5	Нийт орлого	мян.төг	23,089,000.0	6,783,945.9	-16,305,054.1	29.4
6	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	22,825,000.0	6,454,204.3	-16,370,795.7	28.3
7	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	150,000.0	167,709.8	17,709.8	111.8
8	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	70,000.0	117,719.8	47,719.8	168.2
9	Халаалтын орлого	мян.төг	44,000.0	44,312.0	312.0	100.7
10	Нийт зардал	мян.төг	20,788,599.5	7,775,570.8	-13,013,028.7	37.4

11	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	16,784,049.6	5,635,073.6	-11,148,976.0	33.6
12	Нүүрснээс бусад бараа материал борлуулсны өртөг	мян.төг	150,000.0	138,308.0	-11,692.0	92.2
13	Уурын зуухны зардал	мян.төг	189,647.1	196,481.7	6,834.6	103.6
14	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	95,629.9	43,940.6	-51,689.3	45.9
15	Удирдлагын зардал	мян.төг	1,428,435.4	1,154,038.6	-274,396.8	80.8
16	Борлуулалтын ажиллагааны зардал	мян.төг	1,347,837.5	476,847.2	-870,990.3	35.4
17	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	793,000.0	130,881.1	-662,118.9	16.5
18	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	2,300,400.5	-991,624.9	-3,292,025.4	-143.1
19	Орлогын албан татвар	мян.төг	230,040.1			
20	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,070,360.5	-991,624.9	-3,292,025.4	-147.9

Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Могойн гол ХК ба түүний үйл ажиллагаа

Могойн гол ХК нь 1970 онд Могойн голын уурхай нэрээр анх үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 35 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна. Могойн гол ХК нь 51 хувийн орон нутгийн өмчийн оролцоотой компани бөгөөд 49 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Нийт хувьцааны тоо 829,622 ширхэг ба үүнээс Хөвсгөл аймгийн ИТХ 423,107 ширхэг, цөөнх хувьцаа эзэмшигчид 406,515 ширхэг хувьцаа эзэмшиж байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны зах зээлийн үнэ /22,500 төгрөг/ нэгж хувьцааны дансны үнээс /4,093 төгрөг/ өндөр байгаа нь компанийн хөрөнгийн бодит үнэ дансны үнээс өндөр байгааг харуулж байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ нь 9 гишүүн, үүнээс орон нутгийн өмчийн төлөөлөл 5 гишүүн, цөөнх хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл 4 гишүүнээс бүрдэж байна. Компанийн зорилго нь үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн олон улсын чанар стандартад нийцүүлсэн нүүрсийг олборлож, ажилтнуудаа аюулгүй орчинд сэтгэл хангалуун ажиллаж өсөх дэвших боломжоор ханган ажиллаж эдийн засгийн хувьд бие даасан орон нутгийн хөгжлийг тэргүүлэгч компани болоход оршино. Могойн гол ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсанд ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулах
- Ашигт малтмалыг боловсруулах, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдах худалдан авах импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдаа эрхлэх
- Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх

Могойн гол ХК нь эрчим хүчний болон коксжих нүүрс олборлож, ААН, иргэдэд борлуулах үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг ба тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас гадна уурын зуухаар дулаан үйлдвэрлэж өөрийн хэрэгцээнд болон багийн төвд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлдэг байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Могойн гол ХК нь эрчим хүчний болон коксжих нүүрсний борлуулалт хийдэг ба эрчим хүчний нүүрсний борлуулалтаас алдагдал хүлээж, коксжих нүүрсний борлуулалтаас алдагдлаа нөхөж байдаг. Энэ хуулийн "10.2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д

заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина.” гэсэн заалтын дагуу коксжих нүүрсээ биржээр зарж борлуулах шаардлагатай болсон. Коксжих нүүрсний үнэ Хятад улсын зах зээлээс шууд хамааралтай ба Хятад улс гангийн үйлдвэрүүдээ багасгах бодлоготой холбоотойгоор нүүрсний үнэ 2025 онд өмнөх оноос 20 орчим хувиар сулраад байна. Хөвсгөл аймгийн ИТХ-аас коксжих нүүрсний тээвэрлэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ээс дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний хооронд явуулж байхаар хязгаарласан. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2022 оны 12 сарын 23-нд УИХ-аар батлагдаж, 2023 оны 6 сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчлагдсан. Хууль хэрэгжихээс өмнө 19 аж ахуйн нэгжтэй 140.0 мянган тонн коксжих нүүрсийг худалдахаар гэрээ хийсэн нь дээрх хуулиас шалтгаалан борлуулалт хийх боломжгүй болсон. Шинээр бирж дээр нүүрс борлуулахын тулд Мөрөн-Эрдэнэт чиглэлийн тээврийн тендерт шалгаруулж шалгарсан компанитай гэрээ байгуулах шаардлагатай боловч одоогоор шаардлага хангасан компани гараагүй байна. Мөн Эрдэнэт хотод итгэмжлэгдсэн гаалийн талбайтай байх ёстой. Компанийн удирдлагаас АҮЭБЯ-ны биржийн хуулийн ажлын хэсэгт хүсэлт гаргасны дагуу үүсээд байгаа нөхцөл байдлыг судлахаар болсон байна.

Тайлант онд нь нийт 198 ажиллагсадтайгаар 2,500.0 мянган тонн хөрс хуулалтын ажил хийж 250.0 мянган тонн нүүрс олборлож, борлуулах зорилго тавьж ажилласнаас 1,131.9 мянган тонн хөрс хуулалтын ажил хийж 140.0 мянган тонн нүүрс олборлож, 117.4 мянган тонн нүүрс борлуулжээ. Дээрх байдлаас харахад компани хөрс хуулалт бизнес төлөвлөгөөнд заасан хэмжээний 45.3 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Коксжих нүүрсний борлуулалт буурснаас шалтгаалан богино хугацааны төлбөрийн чадвар суларсан байна. Дээрх гадаад дотоод таагүй хүчин зүйлс нь компанийн тасралтгүй үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компанид дараах хууль эрх зүйн зохицуулалтуудыг үйл ажиллагаандаа голлон ашиглаж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Уул уурхайн биржийн тухай хууль,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль,
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тогтоол,
- Могойн гол ХК-ийн ТУЗ-ын тогтоол
- Бусад холбогдох хууль.

Тайлант хугацаанд дээрх хуулиудад тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээний өөрчлөлт гаргаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Компанийн дотоод хяналт ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын түвшинд хэрэгждэг. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу компанийн захирлын 2022 оны 05 сарын 12-ны өдрийн А-28 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2024 онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд тусгагдаж батлуулсан зардлууд болон норм нормативыг мөрдөж байгаа эсэх, түлш шатахуун, цалин, хоолны зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавихаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт

шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1¹ дэх заалт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могойн гол ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэх үүрэгтэй. Аккруэл сууриар бүртгээгүйтэй холбоотой алдааг 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтөд тусгасан.

Могойн гол ХК нь 2022 оны 11 дүгээр сараас нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдөж байгаа ба нягтлан бодох бүртгэлд UNICUS программыг ашигладаг.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Могойн гол ХК санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь Могойн гол ХК-ийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,585.8 сая төгрөгөөр буюу 82.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	100,475.2	20,541.3	-79,933.9
Авлага	513,370.5	584,806.7	71,436.2
Бараа материал	8,216,479.4	16,573,378.8	8,356,899.4
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	625,185.3	668,727.3	43,542.0
Бусад эргэлтийн хөрөнгө	11,709.2	446.6	-11,262.6
Үндсэн хөрөнгө	2,155,850.1	3,361,018.4	1,205,168.3
Нийт хөрөнгө	11,623,069.6	21,208,919.1	9,585,849.5
Богино хугацаат төлбөр	5,948,231.1	17,023,478.6	11,075,247.5
Урт хугацаат өр төлбөрийн дүн	789,831.0	789,831.0	0.0
Эздийн өмч	4,885,007.6	3,395,609.5	-1,489,398.1

¹ Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,623,069.6	21,208,919.1	9,585,849.5
---------------------------------------	--------------	--------------	-------------

Хөрөнгө, өр төлбөрт орсон өөрчлөлтийг тодруулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Төрийн банк, ХААН банкны харилцах дансны үлдэгдэл 79.9 сая төгрөгөөр буурч 20.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 71.4 сая төгрөгөөр өссөн байна. Авлага өсөхөд дансны авлага 125.5 сая төгрөг, бусад авлага 33.1 сая төгрөгөөр өсөж, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 87.7 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна. Найдваргүй авлагын нөөцийг шууд аргаар байгуулдаг ба 125.5 сая төгрөг ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.
3. Бараа материал данс 3,795.0 сая төгрөгөөр өсөхөд хөрс хуулалтын ажилтай холбоотой дуусаагүй үйлдвэрлэл данс 4,258.3 сая төгрөгийн зардал хуримтлагдсантай холбоотой.
4. Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл 43.5 сая төгрөгөөс өсөхөд түрээсийн тоног төхөөрөмжийн урьдчилгаа, нүүрс ялгах үйлдвэрийн урьдчилгаанд төлсөн ажил тайлант онд хийгдээгүйтэй холбоотой байна
5. Үндсэн хөрөнгө 1,205.2 сая төгрөгөөр өсөхөд ХААН банкнаас зээлээр 1,212.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь нөлөөлсөн байна.
6. Богино хугацаат өр төлбөр 11,075.2 сая төгрөгөөр өсөхөд дансны өглөг 6,819.4 сая төгрөг, татварын өр 573.0 сая төгрөг, НДШ-ийн өглөг 204.9 сая төгрөг, урьдчилж орсон орлого 2,264.2 сая төгрөг, тайлант онд банкнаас авсан зээл 1,212.0 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 477.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.
7. Эзний өмч 1,489.4 сая төгрөгөөр буурахад 2023 оны ногдол ашиг төлөхөөр зарласан 497.8 сая төгрөг, тайлант оны алдагдал 991.6 сая төгрөг байсан нь нөлөөлжээ.

Дээрх данснуудтай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Тайлант онд 11.3 сая төгрөгийн хүүгийн зардлыг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" заалттай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан байна. "Могойн гол" ХК-ийн ТУЗ нь 03 дугаар сарын 28-ны 09 дүгээр тогтоолоор компанийн зорилтот түвшнийг 23,089.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 20,788.6 сая төгрөгийн зардал гарган, 2,300.4 сая төгрөгийн ашигтай ажиллагаар тогтоосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт

Гүйцэтгэлээр 6,783.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 7,775.5 сая төгрөгийн зардал гарган, 991.6 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

График 1. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг биет хэмжээгээр харуулбал:



Нийт орлогын гүйцэтгэл 6,783.9 сая төгрөг болж 991.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь коксжих нүүрсний орлого буурснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 7,775.5 сая төгрөг болж, төлөвлөгөөнөөс 52.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд төлөвлөсөн нүүрс олборлолтоо 44.0 хувиар дутуу гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд алдагдалтай

ажилласан тул ногдол ашиг зарлаагүй байна.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн	Хувь
1	Урд оноос шилжсэн нүүрс	мян.тн	40.2	40.2	0.0	100.0
2	Хөрс хуулалт/мян.м3/	мян.тн	2,500.0	1,131.9	-1,368.1	45.3
3	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	140.0	-110.0	56.0
4	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	117.4	-132.6	47.0
5	Нийт орлого	мян.төг	23,089,000.0	6,783,945.9	-16,305,054.1	29.4
6	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	22,825,000.0	6,454,204.3	-16,370,795.7	28.3
7	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	150,000.0	167,709.8	17,709.8	111.8
8	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	70,000.0	117,719.8	47,719.8	168.2
9	Халаалтын орлого	мян.төг	44,000.0	44,312.0	312.0	100.7
10	Нийт зардал	мян.төг	20,788,599.5	7,775,570.8	-13,013,028.7	37.4
11	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	16,784,049.6	5,635,073.6	-11,148,976.0	33.6
12	Нүүрснээс бусад бараа материал борлуулсны өртөг	мян.төг	150,000.0	138,308.0	-11,692.0	92.2
13	Уурын зуухны зардал	мян.төг	189,647.1	196,481.7	6,834.6	103.6
14	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	95,629.9	43,940.6	-51,689.3	45.9
15	Удирдлагын зардал	мян.төг	1,428,435.4	1,154,038.6	-274,396.8	80.8
16	Борлуулалтын ажиллагааны зардал	мян.төг	1,347,837.5	476,847.2	-870,990.3	35.4
17	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	793,000.0	130,881.1	-662,118.9	16.5
18	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	2,300,400.5	-991,624.9	-3,292,025.4	-147.9
19	Орлогын албан татвар	мян.төг	230,040.1			
20	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,070,360.5	-991,624.9	-3,292,025.4	-147.9

Зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотой дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

Могойн гол ХК нь тайлант онд хөрс хуулалтын ажлыг 1,368.1 мянган м3 дутуу буюу 45.3 хувь, олборлох нүүрсний хэмжээг 110.0 мянган тонноор дутуу буюу 56.0 хувь, борлуулах нүүрсний хэмжээг 132.6 мянган тонноор дутуу буюу 47.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласнаас нийт орлогыг 16,305.0 сая төгрөг буюу 70.6 %-аар дутуу биелүүлж, 991.6 сая төгрөгийн

алдагдалтай ажиллаж, нийт ашгийн зорилтот түвшнийг 3,062.0 сая төгрөгөөр хангаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." заалт, Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөг биелүүлээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

Могойн гол ХК нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, тайлант Шилэн дансны цахим системд нийтэлж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнийг дагаж гарсан журмуудыг мөрдөж ажилласан боловч 2022-2023 ондуудад зохион байгуулсан дараах худалдан авалтын гүйцэтгэлийг хангаагүй байна. Үүнд:

Илрүүлэлт:

Таванхаан коул ХХК-тай хуурай аргаар баяжуулах үйлдвэр авахаар 221.0 сая төгрөг, Туасиа ХХК –аас тоног төхөөрөмж түрээслэхээр 311.7 сая төгрөгийг 2023 онд урьдчилж төлсөн боловч дээрх компаниуд одоо болтол гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй: 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Өгсөн зөвлөмж: Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ болон хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангах
- Бусад мөнгөн зарлагын ангилалаас тайлант хугацаанд хэмжээний 1,994.4 сая төгрөгийн 286 ажил, гүйлгээг бүртгэж санхүүжүүлсэн байна. Аудитаар 5.0 сая төгрөгөөс дээш 52 ажил гүйлгээг хянахад зөрчилтэй асуудал гараагүй.
- Могойн гол ХК -ын ТУЗ-ын 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 198 орон тоотой байхаар баталсан байна. Тайлант онд батлагдсан орон тоог хэтрүүлээгүй ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Могойн гол ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч этгээдэд зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, үндсэн хөрөнгө, дотоод хяналт, авлага, төлбөр, ТУЗ-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Могойн гол ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 7,775.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 155.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 124.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлсэн байдлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар шалгана.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох бизнес төлөвлөгөөний тайлан, үйлдвэрлэлийн бусад үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Тайлант онд нийт 94 бараа, ажил, үйлчилгээг 34,866.7 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 56 бараа, ажил, үйлчилгээнд 27,610.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагаа 59.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөсөн орлого тасарсантай холбоотой байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг 3.5-д тусгасан.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 4 төлбөрийн акт, 3 албан шаардлага, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэл, зорилтот түвшинтэй холбоотой 5 зөвлөмж өгснөөс 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 22.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт төлөгдөөгүй, гүйцэтгэх захиралд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага биелээгүй байна. Компанийн гүйцэтгэх захиралд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг биелүүлээгүй асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрлэхээр шилжүүллээ.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	40,619.5	4	18,653.0	41.0
Албан шаардлага	3	193,249.7	3	193,249.7	100.0
Зөвлөмж	5	2,916,470.6	5	2,916,470.6	60.0
Нийт дүн	12	3,150,339.8	9	2,969,399.7	75.0

Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 22.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акттай холбоотой асуудал шүүхэд шилжүүлсэн боловч шийдвэр нь гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар дараах зөрчлүүдийг дараагийн аудитаар анхаарах асуудал гэж шийдвэрлээ. Үүнд:

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар компанийн ТУЗ-д өгсөн “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захиралд хариуцлага тооцох албан шаардлагыг биелүүлээгүй асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудал гэж үзлээ.
2. Компанид үүссэн санхүүгийн хүндрэл нь тасралтгүй үйл ажиллагааны чадавхад нөлөөлж байгаа асуудлыг аймгийн ИТХ-д хандаж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,606.1 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс, илэрсэн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Компанийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Компанийн өр төлбөр эздийн өмчийн дүнгээс 2023 онд 1,853.0 сая төгрөг, 2024 онд 14,417.7 сая төгрөгөөр илүү болж төлбөрийн чадварыг алдагдуулж байна. Энэ нь

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1² заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бий болсон байна.

Өгсөн зөвлөмж:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлбөрийн чадвар болон компанийн санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон хүндрэлтэй асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэх

Гүйцэтгэх захиралд:

1. Компанийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТУЗ-өөс баталсан нүүрсний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 16,370.8 сая төгрөг буюу 71.7%-аар дутуу биелүүлж, зорилтот түвшнээс 3,062.0 сая төгрөгөөр дутуу буюу 991.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." заалт, Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөг биелүүлээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Таванхаан коул ХХК-тай хуурай аргаар баяжуулах үйлдвэр авахаар 221.0 сая төгрөг, Туасиа ХХК –аас тоног төхөөрөмж түрээслэхээр 311.7 сая төгрөгийг 2023 онд урьдчилж төлсөн боловч дээрх компаниуд одоо болтол гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй: 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ болон хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангах

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 11.3 сая төгрөгийн хүүгийн зардлыг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө" заалттай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зээлийн хүүгийн зардлыг аккрузл сууриар бүртгэж, тайлагнаж байх

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг

² Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна: ...61.1.4 "Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон..."

журам"-ын 3.1³ дэх заалт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх
Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй	1	3,061,985.4					1	3,061,985.4
Санхүүгийн сөрөг үзүүлэлтүүд компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна	1						1	
Банкны зээлийн 11.3 сая төгрөгийн хүүгийн зардлыг бүртгээгүй байна	1	11,356.3					1	11,356.3
Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна	1						1	
Дүн	4	3,073,341.7					4	3,073,341.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах, түрээслэх гэрээ хийсэн компаниуд гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй байна.	1	532,727.3					1	532,727.3
Дүн	1	532,727.3					1	532,727.3

³ Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.